



ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ 2023




Улаанбаатар
2024он



ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индекс 2023 оны эцэст - 0.8 хувь болж, өмнөх оныхоос -0.1 пунктээр буурчээ. 2017 онд 2.5 пунктээр өсч 9.7 хувь, 2018 онд 1.8 пунктээр буурч 0.7 хувь, 2019 онд 0.1 пунктээр буурч 0.6 хувь, 2020 онд -1.7 хувь болж 1.1 пунктээр буурч, 2021 онд 1.7 пунктээр буурч 2.6 2022 онд өмнөх оноосоо 0.9 болж 1.7 пунктээр буурчээ.

ЗУРАГ 1. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, 2021-2023 оны сар бүрээр



Хэрэглээний үнийн индекс 2023 оны 12 дугаар сарыг өмнөх оны жилийн эцэстэй харьцуулахад 8.6 хувиар өсөхөд хүнсний бараа, согтууруулах бус ундаа бүлгийн үнэ 12.6 хувь, согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис бүлгийн үнэ 4.6 хувь, хувцас, бөс бараа, гутал бүлгийн үнэ 6.6 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш бүлгийн үнэ 6.3 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа бүлгийн үнэ 6.3 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 8.0 хувь, тээврийн бүлгийн үнэ 0.4 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ бүлгийн үнэ -0.2 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ бүлгийн үнэ 3.4 хувь, Боловсролын үйлчилгээ бүлгийн үнэ 21.2 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ бүлгийн үнэ 17.5 хувь, Даатгал, санхүүгийн үйлчилгээ бүлгийн үнэ 2.8 хувь, бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ 22.4 хувиар тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

ХҮСНЭГТ 1 . ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, барааны бүлгээр

Бараа, үйлчилгээний бүлгийн нэр	<u>2022-XII</u> 2021-XII	<u>2023-XII</u> 2022-XII	<u>2023-XII</u> 2022-XII	<u>2023-XII</u> 2023-XI
Ерөнхий индекс	112.9	108.6	108.6	100.2
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	112.8	112.6	112.6	100.5
Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	108.8	104.6	104.6	100.2
Хувцас, бөс бараа, гутал	122.0	106.6	106.6	100.1
Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш	121.3	106.3	106.3	100.3
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	113.8	106.3	106.3	100.1
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	123.2	108.0	108.0	100.0
Тээвэр	103.5	100.4	100.4	100.0
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	103.1	99.8	99.8	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	110.2	103.4	103.4	100.0
Боловсролын үйлчилгээ	110.7	121.2	121.2	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	112.5	117.5	117.5	100.0
Даатгал, Санхүүгийн үйлчилгээ	105.4	102.8	102.8	100.0
Бусад бараа, үйлчилгээ	124.6	122.4	122.4	100.4

ХҮСНЭГТ 2. УЛААНБААТАР ХОТЫН ХЭРЭГЛЭЭ-ний үнийн сарын индекс, /**эерэг,сөрөг**/

Бараа, үйлчилгээний бүлэг	Үнийн өөрчлөлт хувь	Дэд бүлэг, зарим барааны үнийн өөрчлөлт
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	0.5	Энэ бүлгийн үнийн бууралтад Талх, гурил будааны үнэ 0.4 хувиар, Мах, Махан бүтээгдэхүүний үнэ 1.5 хувиар, Загас далайн бүтээгдэхүүний үнэ 3.2 хувиар, Жимс, Жимсгэний үнэ 0.3 хувиар, Сахар, Жимсний чанамал, Зөгийн бал, чихэр шоколад бүлгийн үнэ 0.1 хувиар, Бэлэн хоол, хүнсний бусад бүтээгдэхүүн бүлгийн үнэ 0.2 хувиар, Бүх төрлийн кофе, цай, какао бүлгийн үнэ 0.2 хувиар, Цай бүлгийн үнэ 0.1 хувиар, Ундаа бүлгийн үнэ 0.3 хувиар тус тус өссөн нь нөлөөлөв.
Согтууруулах ундаа, Тамхи, мансууруулах бодис	0.2	Энэ бүлгийн өсөлтөд Архи, спирт бүлгийн үнэ 0.1 хувиар, шар айраг бүлгийн үнэ 2.8 хувиар өссөн нь тус тус нөлөөлөв.
Хувьцас, бөс бараа, гутал	0.1	Энэ бүлгийн үнийн өсөлтөд Бүх төрлийн гуталны үнэ 0.2 хувиар, Хувьцас, бөс бараа бүлгийн үнэ 0.1 хувиар өссөн нь тус тус нөлөөлөв.
Орон сууц, Ус, Цахилгаан, Хийн болон бусад түлш	0.3	Энэ бүлгийн өсөлтөд цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ 0.5 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	0.1	Энэ бүлгийн үнийн өсөлтөд Гэр ахуйн цэвэрлэгээний болон бусад жижиг бараа, гэрийн үйлчилгээний үнэ 0.1 хувиар, Гэр ахуйн цэцэрлэгийн зориулалттай хөдөлмөрийн багаж хэрэгсэлийн бүлгийн үнэ 1.5 хувиар өссөн нь тус тус нөлөөлөв.
Бусад бараа, үйлчилгээ	0.4	Энэ бүлгийн үнийн өсөлтөд Гоо сайханы хэрэгцээнд зориулсан бусад эд зүйлсийн үнэ 0.2 хувиар, Үсчин болон гоо сайхны үйлчилгээний үнэ 1.6 хувиар өссөн нь нөлөөлжээ.


2023 оны 12 дугаар сарын 21 -ний өдрийн үнийн ажиглалтаар Хан-Уул дүүргийн хүнсний зах, дэлгүүрүүдээр худалдаалагдаж байгаа хүнсний өргөн хэрэглээний 16 нэр төрлийн бүтээгдэхүүний дундаж үнийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад “Талх чихэр” ХК-ны “Атар” талхны үнэ 300 төгрөг, “Хонины мах”, ястай 1300 төгрөг, “Үхрийн мах”, ястай 2000, “Алтан тариа” ХК-ийн 1-р зэргийн гурил 420 төгрөг, Алтан тариа” ХК-ийн дээд зэргийн гурил 410 төгрөг, “Алтан тариа” ХК-ийн 2-р зэргийн гурил 360 төгрөг, элсэн чихэр 300 төгрөг, лууван 1200 төгрөг, манжин 3300 төгрөг, сонгино 500 төгрөг, польш алим 400 төгрөг, задгай сүү 1000 төгрөг, Тараг, цөцгийтэй, “Сүү” ХК 340 төгрөг, төмс 400 төгрөг, цагаан будаа 1980 төгрөгөөр тус тус өссөн байна. Харин байцааны үнэ тогтвортой байла

ХҮСНЭГТ 3. БАРААНЫ ДУНДАЖ ҮНЭ, төгрөг, жил бүрийн XII сард


Бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж	2022.XII	2023.XII	$\frac{2023}{2022}\%$
Талх "Атар", "Талх чихэр" ХК	Ширхэг	2100	2 400	114.3
Хонины мах, ястай	Кг	8 500	9800	115.3
Үхрийн мах, ястай	Кг	12 500	14 500	116.0
Гурил , дээд зэрэг, "Алтан тариа" ХК,	Кг	2 540	2 950	116.1
Гурил ,1-р зэрэг, "Алтан тариа" ХК, задгай	Кг	2 180	2 600	119.3
Гурил, 2-р зэрэг, "Алтан тариа" ХК,	Кг	1 200	1 560	130.0
Элсэн чихэр	Кг	4 200	4 500	107.1
Төмс, монгол	Кг	1 600	2 000	125.0
Байцай, монгол	Кг	2 000	2 000	100.0
Лууван, монгол	Кг	1 600	2 800	175.0
Манжин, монгол	Кг	3 200	6 500	203.1
Сонгино, хятад	Кг	3 000	3 500	116.7
Цагаан будаа	Кг	4 420	6 400	144.8
Алим, Польш	Кг	7 600	8 000	105.3
Сүү, задгай	литр	3 000	4 000	133.3
Тараг, цөцгийтэй, "Сүү" ХК	литр	3 800	4 140	108.9

*Тайлбар: Худалдаа үйлчилгээний "Мөнхсуврага" төв



ЗУРАГ 2 . НЭГ КГ ХОНИНЫ МАХНЫ дундаж үнэ, төгрөг




ЗУРАГ 3. НЭГ КГ ҮХРИЙН МАНХНЫ дундаж үнэ, төгрөг



ЗУРАГ 4 . НЭГ КИЛОГРАММ ХҮНСНИЙ НОГООНЫ ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн XII





ЗУРАГ 5 . НЭГ КИЛОГРАММ САВЛАСАН ГУРИЛЫН ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн XII сард, төгрөг



ХҮСНЭГТ 4. НЭГ ЛИТР ШАТАХУУНЫ ҮНЭ, төгрөг

ШТС	2022.XII.21					2023.XII.21				
	Аи 95	Аи 80	Аи 92	Дизель түлш	Газ	Аи 95	Аи 80	Аи 92	Дизель түлш	Газ
Петровис	3 910	2 370	2 390	3 850	-	3 980	2 370	2 390	3 910	-
Магнай трейд	3 910	-	2 390	3 980	-	3 910	-	2 390	3 890	-
Сод монгол	3 910	2 320	2 390	3 850	-	3 910	2 370	2 390	3 890	-
Шунхлай	3 910	2 350	2 390	3 850	-	3 910	-	2 390	3 890	-
Юнигаз	-	-	-	-	1 790	-	-	-	-	1 790
Дундаж үнэ	3 910	2 347	2 390	3 882	1 790	3 927	2 370	2 390	3 895	

Эх сурвалж: Нийслэлийн хүн амын өргөн хэрэглээний үнийн 12-р сарын мэдээ

Ойлголт, тодорхойлолт:

Хэрэглээний сагс: Үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн дундаж өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалтыг ойлгоно.

Хэрэглээний бараа, үйлчилгээний жин: Өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувь.

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ): Хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

Тооцох аргачлал:

ХҮИ-ийг хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашиглан, хувиргасан үнийн Ласпейресийн индексийн томъёогоор тооцно. Үүнд:

$$I_{ct}^L = \sum \left(\frac{P_{it}}{P_{it-1}} \right) \left(\frac{P_{it-1}}{P_{it-2}} \right) \dots \left(\frac{P_{i2}}{P_{i1}} \right) \left(\frac{P_{i1}}{P_{i0}} \right) \frac{P_{i0} Q_{i0}}{\sum P_{i0} Q_{i0}}$$

I_{ct}^L – t тайлант үеийн Ласпейресийн үнийн индекс
t – Тайлант үе
0 – суурь үе
 p_t^i – i барааны тайлант үеийн үнэ
 p_0^i – i барааны тайлант үеийн үнэ
 q_0^i – i барааны тайлант үеийн үнэ

ХҮИ-ийн үнэн зөв жинг 5

сагсны төлөөлөх чадварыг нэмэгдүүлэх, байдлыг хангах үүднээс хэрэглээний сагс, жилд нэг удаа шинэчилдэг. Хэрэглээний бараа, үйлчилгээний сагсыг Улаанбаатар хотод 344 бараа, үйлчилгээ (аймагт 238 бараа, үйлчилгээ)-ээр бүрдүүлж, Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны 2015 оны үр дүнгээр жинг тооцон, 2015 оны шинэчилсэн суурьтайгаар 2017 оны 4 дүгээр сараас эхлэн тархааж байна. ХҮИ-ийг тооцохдоо бараа, үйлчилгээний геометр дундаж үнийг ашигласан.

Танилцуулга бичсэн: Статистикийн хэлтсийн мэргэжилтэн Н.Болор-Эрдэнэ